



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 7/2018

Мандатлов

Г Үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлж,
нөхөн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга Г.Самданцоодолд ар гэрийн гачигдал гарсан тул Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажил" болон "Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, гадна цэвэр усны ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаас чөлөөлсүгэй.

Хоёр. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажил"-ын үнэлгээний хорооны даргаар Б.Түвшинбаяр /ХЭЗХ-ийн дарга/, "Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, гадна цэвэр усны ажил"-ын үнэлгээний хорооны даргаар М.Цогзолмаа /ТЗУХ-ийн дарга/ нарыг нөхөн томилсугай.

Гурав.Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Б.Түвшинбаяр/, /М.Цогзолмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0219589

